



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/102

Чингис хот

“Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих
нийтлэг шаардлага”-ын хэрэгжилтэд хяналт
тавих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан “Өдөр өнжүүлэх үйлчилгээ, эрхлэхэд тавих нийтлэг шаардлага”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн үйлчилгээ эрхлэх орчин, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Уянга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч, ахлах мэргэжилтэн
	Ц.Мөнгөнбаяр	Боловсрол, соёл, урлагийн газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн
	Н.Мөнхчимэг	Мэргэжлийн хяналтын газрын эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга
	О.Баярмагнай	Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч

2. Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлагыг мөрдүүлэн хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах асуудлаар үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж чиглэл өгч ажиллахыг ажлын хэсгийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

231010467

2.

2. Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлагын хэрэгжилтэд хийсэн хяналт үнэлгээний үр дүнг Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албанд улирал бүр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Х.Уртнасан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ